МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.08.14 № 49

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
С.НАРАНЦОГТ ТАНАА

Инфляцын өсөлт, мөнгөний бодлогын
үр нөлөөний талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 8 дахь заалт, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, мөн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 97 дугаар тогтоолоор батлсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл"-ийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг тавьж байна.

1.2026 оны 7дугаар сарын байдлаарх 13.0 хувийн инфляцаас Монголбанкны мөнгөний бодлогоор нөлөөлөх боломжтой дотоод эрэлт, зээл, мөнгөний нийлүүлэлт, төгрөгийн ханш, инфляцын хүлээлт болон анхны үнийн өсөлтөөс бусад бараа, үйлчилгээнд дамжсан нөлөө нийлээд хэдэн нэгж хувийг бүрдүүлсэн талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, үнэлгээ, тайлбар;

2.2024 оны 1 дүгээр улирлаас 2026 оны 2 дугаар улирал хүртэл Монголбанкнаас боловсруулсан инфляцын 3, 6, 12 сарын төсөөллийг бодит гүйцэтгэлтэй харьцуулж, зөрүүний хэмжээ, гол шалтгаан, давтан дутуу болон хэтрүүлэн үнэлсэн хүчин зүйл, төсөөллийн алдаанд хийсэн дотоод үнэлгээ, алдааг залруулах чиглэлээр авсан арга хэмжээний талаарх холбогдох хүснэгт, судалгаа, тооцоо, мэдээлэл, тайлбар;

3.2026 оны 5 дугаар сард инфляц 11.2 хувьд хүрсэн байхад Мөнгөний бодлогын хороо 6 дугаар сарын 23, 24-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан боловч 8 дугаар сарын 12-нд ээлжит бусаар хуралдаж бодлогын хүү болон заавал байлгах нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 6 дугаар сарын 24-өөс 8 дугаар сарын 12-ны хооронд инфляц, үнийн өсөлтийн дам нөлөө, инфляцын хүлээлтийн талаарх өмнөх үнэлгээг өөрчлөхөд хүргэсэн мэдээлэл, үзүүлэлт, 11.2 хувийн инфляцыг түр зуурын шинжтэй гэж үзсэн үндэслэл, нэмэлт арга хэмжээ авах шаардлага хэзээ үүссэн гэж үзсэн болон уг арга хэмжээг өмнө авах боломж байсан эсэхэд хийсэн үнэлгээний талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, шийдвэрийн үндэслэл, тайлбар;

2026009143

4.2024 оны 9 дүгээр сард Монголбанк инфляц, дотоод эрэлт, зээлийн өсөлтийн эрсдэлийг анхааруулсан нөхцөлд бодлогын хүүг 11 хувиас 10 хувь болгон бууруулж, төгрөгийн заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар нэмэгдүүлсэн бодлогын хосолсон шийдвэр инфляц, зээл, дотоод эрэлтэд ямар нөлөө үзүүлсэн, бодит гүйцэтгэл гарсны дараа уг шийдвэрт хийсэн дотоод үнэлгээ, тухайн шийдвэр оновчтой байсан эсэх талаарх өнөөгийн дүгнэлт, үнэлгээний алдаа гарсан бол түүнд үндэслэн авсан арга хэмжээний талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, дотоод үнэлгээ, тайлбар;

5.2024-2026 онд зээл болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлт дотоод эрэлт, хэрэглээ болон импортод хэт дарамт учруулах эрсдэлийг Монголбанк хэзээ, ямар үзүүлэлтээр тогтоосон, уг эрсдэлийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүгээс гадна заавал байлгах нөөц, зээлд чиглэсэн зохицуулалт болон бусад арга хэмжээг ямар үндэслэлээр авч хэрэгжүүлсэн, эдгээр арга хэмжээний үр нөлөөг хэрхэн үнэлсэн талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, шийдвэрийн үндэслэл, тайлбар;

6.2024-2026 оны төсвийн бодлого, төсвийн зарлагын тэлэлт дотоод эрэлт болон инфляцад хэдий хэмжээний нэмэлт дарамт үзүүлсэн талаарх Монголбанкны тооцоо, уг дарамтыг мөнгөний бодлогын зорилтод эрсдэл учруулах түвшинд хэзээ хүрсэн гэж үнэлсэн, энэ талаар Засгийн газар, Сангийн яам, Улсын Их Хуралд хүргүүлсэн санал, анхааруулга, бодлогын зөвлөмжийн талаарх холбогдох судалгаа, тооцоо, албан мэдээлэл, тайлбар;

7.Монголбанкны тооцоогоор мөнгөний бодлогын арга хэмжээ дотоод эрэлт болон инфляцад хэдий хугацааны дараа, ямар хэмжээгээр нөлөөлдөг, 2026 оны 8 дугаар сарын 12-ны шийдвэр инфляцад хэзээнээс, ямар хэмжээгээр нөлөөлөхөөр тооцож байгаа талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, тайлбар;

8.Инфляц зорилтот түвшнээс мэдэгдэхүйц хазайсан үед бодлогын хариу арга хэмжээ хоцрох, төсөөлөл болон эрсдэлийн үнэлгээний алдаа давтагдахаас сэргийлэх зорилгоор инфляцын зорилтоос хазайлтын шалтгаан, Монголбанкны нөлөөлөх боломжтой хэсэг, авсан болон авах арга хэмжээг тусгайлан тайлагнах, эрсдэлийг эрт илрүүлэх үзүүлэлт болон бодлогын шийдвэрийг дахин үнэлэх шалгуурыг тодорхой болгох, төсөөллийн алдааг тогтмол үнэлж нийтэд мэдээлэх, Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн тооцоо, үндэслэл, гол эрсдэлийг илүү нээлттэй болгох чиглэлээр хийхээр төлөвлөж буй өөрчлөлт, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээлэл, үндэслэл, төлөвлөгөө, тайлбар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА

2026009143